

Огноо: 2024.09.25

№ 57

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүнийг түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 05/10309 албан тоот, Монголбанкны 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн А-1/506 албан тоотыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн ердийн гишүүн Д.Цолмонгийн оронд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцож, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаж байгаа Х.Пүрэвсүрэнг 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн нөхөн сонгууль хүртэлх хугацаанд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр түр томилсугай.

2. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр түр томилогдсон Х.Пүрэвсүрэнд Банкны тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН